

ХӨДӨЛГӨӨНГ ЗУРАГ

6-Р АНГИ

I ҮЕ ШАТ АСУУДАЛ ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ

- АМЬТДЫН ЗАН АВИР, ХӨДӨЛГӨӨНИЙГ СУДАЛЖ, ТЭД БИЕИЙН ХӨДӨЛГӨӨНӨӨРӨӨ СЭТГЭЛ ХӨДЛӨЛӨӨ ЯАЖ ИЛЭРХИЙЛДЭГИЙГ, ӨНГӨ, ХЭЛБЭРИЙГ ЯРИЛЦЪЯ.
- АМЬТАН УУРЛАХ, АРИХИРАХ, БАЯРЛАХ, ИДЭХ, ТОНШИХ, ЯВАХ, СУУХ, СҮҮЛЭЭ ХӨДӨЛГӨХ ГЭХ МЭТ ХӨДӨЛГӨӨНҮҮДИЙГ ЯМАР ҮЕДЭЭ ГАРГАДАГ БОЛОХЫГ ЯРИЛЦЪЯ.

АСУУДАЛ ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ

Хүснэгт 3.4



Аль хэсэг нь
хөдлөх вэ?

Толгой хөдлөх

Ямар зан ааш
илэрхийлэх вэ?

.....




.....

Тонших, нисэх



Сүүл сарвуу
хөдлөх

.....



.....

Баярлах




НУДАРГАН МЕХАНИЗМ

- ХӨДӨЛГӨӨНТ ЗУРАГ ХИЙХИЙН ТУЛД ХӨДӨЛГӨӨН ҮҮСГЭГЧ МЕХАНИЗМИЙН ТАЛААР СУДАЛГАА ХИЙХ ХЭРЭГТЭЙ.
- НУДАРГАН МЕХАНИЗМ НЬ ТӨВӨӨСӨӨ ТОДОРХОЙ ЗАЙД БАЙРЛАСАН ЭРГЭЛТИЙН ТӨВ БҮХИЙ ДУГУЙ ХЭЛБЭРТЭЙ БАЙНА.
- НУДАРГА ТҮЛХЭГЧИЙГ ААЖМААР ӨРГӨХ, БУУЛГАЖ ЖИГД ХӨДӨЛГӨӨН ҮҮСГЭНЭ.
- ЭНЭ НЬ ХИЙХЭД ХАМГИЙН ЭНГИЙН БӨГӨӨД ӨРГӨН ХЭРЭГЛЭГДДЭГ МЕХАНИЗМ ЮМ.



Хөдөлгөөн үүсгэдэг мөч, механизмыг ажигла. Эдгээр механизмууд ямар хөдөлгөөн хийж байна вэ? Дэвтэртээ бичээрэй.

Хүснэгт 3.5



Хөдөлгөөн хэрхэн үүсч байгааг тайлбарлан бичээрэй.

Эргэлдэх хөдөлгөөнөөс шилжих хөдөлгөөн үүсгэж байна. Өөрөөр хэлбэл тэнхлэг дээр хэлтгий суусан хавтгай эргэлдэхэд гол дээш доошоо хөдөлгөөн үүсгэж байна.

.....

.....

II ҮЕ ШАТ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ СУДАЛГАА ХИЙХ

Ингээд нударган механизмуудын төрлүүдтэй танилцая.

1. Эксцентрик нударга:

Энэ нь төвийн эргэлдэх төвтэй ердийн нударган механизмын нэг хэлбэр юм. Эксцентрик нударга нь энэ голыг эргүүлэхэд аажмаар дээш доош хөдөлдөг юм.


2. Дун хэлбэрийн нударга: Энэ хэлбэрийн нударган механизм нэг чиглэлд эргүүлэх боломжтой бөгөөд аажмаар дээшилж огцом доош хөдөлдгөөрөө онцлог юм.

3. Лийр хэлбэрийн нударга: Энэ нь зөвхөн дээш аажмаар хөдөлж, эсрэг чиглэлд хөдөлгөөн үүсгэхгүй юм.

4. Зууван хэлбэрийн нударга: Энэ нь нэг эргэлтэд хоёр ба түүнээс доош хөдөлгөөнийг үүсгэдэг.

5. Дугуй хэлбэрийн нударга: Энэ нь тойргийн төвд байрлах цэг бөгөөд ингэснээр хөдөлгөөнгүй болно.


6. Дэвүүр хэлбэрийн нударга: Энэ дэвүүр хэлбэртэй нударга нь зөвхөн нэг чиглэлд хөдөлгөөн дамжуулдаг юм.




3.8 дугаар зураг

III ҮЕ ШАТ ДИЗАЙНЫ ШИНЭ САНАА, ШИЙДЭЛ ГАРГАХ


Доорх зургуудыг сайтар ажиглаарай.



а) Туулай зурах аргачлал



б) Хэрэм зурах аргачлал




в) Янзага зурах аргачлал

ХӨДӨЛГӨӨНТ ЗУРАГТ ӨНГӨ ХЭРХЭН НӨЛӨӨЛЖ БАЙГААГ АЖИГЛААРАЙ.




3.13 дугаар зураг

IV ҮЕ ШАТ БҮТЭЭХ, ТУРШИХ



3.16 дугаар зураг

Хүүхдүүд ээ! Өөрсдийн хийсэн хөдөлгөөнт зургаа сонгосон сэдвийнхээ дагуу чимэглэж засаж сайжруулаарай. Нударган механизмыг зохион бүтээхдээ ундааны бөглөө гэх мэт гарын доорх материал ашиглаарай.



3.17 дугаар зураг

IV ҮЕ ШАТ ҮНЭЛЭХ, ҮР ДҮНГЭЭ ТАНИЛЦУУЛАХ

Үнэлгээ шалгуур	5 оноо	3 оноо	1 оноо
Зурах дараалал болон ажлын зураг зурах	Зурах дараалал болон ажлын зургийг боловсруулахдаа санаагаа бүрэн тусгаж дүрмийн дагуу зурсан бол	Зурах дараалал болон ажлын зурагт санаагаа тусгасан боловч, зураг төслийн алдаа гаргасан бол	Зурах дараалал болон ажлын зургийн гүйцэтгэл дутуу, зураг төслийн алдаа гаргасан бол
Дизайн загварчлал	Бүтээлийнхээ дизайн загварыг гаргахдаа сонгож авсан сэдэв, амьтаддаа тохируулан санаагаа бүрэн тусгасан бол	Өөр бүтээлээс санаа авч ижилхэн хийсэн бол	Өө зүйлээс санаа авсан боловч бүтээлдээ тусгаагүй бол

ТЕХНИК